



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага

MNS 5742:2019

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Улаанбаатар хот
2019 он

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД ОЛГОВ.
СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР 2022-05-05
Монгол Улсын стандарт мөн. Хувилан олшруулахыг хориглоно.

ӨМНӨХ ҮГ

Стандарт, хэмжил зүйн газар нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд улсын стандартчиллын бодлогыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг юм.

Тус Газар нь тухайн салбарын үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Техникийн хорооны хэлэлцэж, зөвшилцсөн стандартын төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэ стандартыг Монгол Улсын Үндэсний номын сангийн Мэдээлэл арга зүй, эрдэм шинжилгээний хэлтсийн дарга Д.Энхтунгалаг, БСШУСЯ-ны Соёл урлагийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Б.Баяраа, ЗГХА-ны Соёл, урлагийн газрын мэргэжилтэн Д.Бямбасүрэн, СУИС-ийн Соёлын сургуулийн Номын сан судлалын тэнхимийн эрхлэгч Т.Хайдав, Хүүхдийн төв номын сангийн захирал Д.Оюунбилэг, ШУТИС-ийн номын сангийн захирал Ч.Гульнар, АШУҮИС-ийн ном зүйч Т.Лувсанням, Монголын номын сангуудын консорциумын удирдах зөвлөлийн дарга Л.Гантулга нар боловсруулсан.

Энэ стандарт нь MNS 5742:2007 стандартыг хүчингүй болгож орлоно.

Энэ стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын дэргэдэх Баримт бичгийн стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэж зөвшилцсөн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Шуудангийн хаяг

Улаанбаатар-13343, Ш/Х - 48

Утас: 976-51-263860 Факс: 976-11-458032

E-mail: standardinform@masm.gov.mn

© СХЗГ, 2019

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

АГУУЛГА

Хуудас

Өмнөх үг	iv
1 Хамрах хүрээ	1
2 Норматив эшлэл	1
3 Нэр томьёо, тодорхойлолт	1
4 Номын сангийн орчны нөхцөл	1
4.1 Нийтлэг шаардлага	1
4.2 Номын сангийн тэмдэглэгээний системийн байрлал	2
4.3 Номын сангийн гадна талбай	2
4.4 Номын сангийн байрны гэрэлтүүлэг	3
4.5 Номын сангийн барилгын дулаан, чийгшил	4
4.6 Номын сангийн байрны эрүүл ахуйн нөхцөл	4
4.7 Номын сангийн шаланд тавих шаардлага	5
5 Уншигчид үйлчлэх байрны орчин	5
6 Сан хөмрөг, хадгаламжийн орчин	6
7 Албан ба туслах байранд тавих шаардлага	7
8 Номын сангийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд тавих шаардлага	10
9 Хамгаалалт ба аюулгүй байдал	11
10 Номын сан-мэдээллийн ажилтанд тавих шаардлага	12
А хавсралт (мэдээллийн) Гал унтраах систем	13
В хавсралт (мэдээллийн) Номын сангийн барилгын агаар солилцох давтамжийн хэмжээ	14
С хавсралт (мэдээллийн) Номын санд түгээмэл ашигладаг хиймэл гэрэлтүүлгийн давуу ба сул тал	15
Д хавсралт (мэдээллийн) Уншлага үйлчилгээний орчин дахь дуу чимээний зохистой түвшин	16
Е хавсралт(мэдээллийн)Уншигчид үйлчлэх байранд ноогдох талбай	17
Ф хавсралт (мэдээллийн) Номын сангийн үйлчилгээний хүрээ, мэргэжлийн албан тушаал, орон тооны жишиг	20
Ж хавсралт (мэдээллийн) Номын сангийн ажлын норм, хэмжээ	22

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 01.140.40; 03.080.30

Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага	MNS 5742:2019
Requirements to the library environment condition and activity	MNS 5742:2007-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн С/30 дугаар тушаалаар батлав.

Энэ стандартыг 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь бүх төрлийн номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих үндсэн шаардлагыг тогтооно.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан баримт бичгийг хэрэглэнэ. Хугацаа заасан эшлэлийн хувьд эш татсан хэвлэл, харин хугацаа заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэлийг хэрэглэнэ.

MNS ISO 11799:2019, *Мэдээлэл ба баримтжуулалт. Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага*

ISO 11620:2014, *Мэдээлэл ба баримтжуулалт. Номын сангийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт*

ISO/TR 11219:2012, *Мэдээлэл ба баримтжуулалт. Номын сангийн барилгын зай талбай, дизайн, үйл ажиллагаанд зориулсан чанарын нөхцөл ба үндсэн статистик*

3 Нэр томьёо, тодорхойлолт

3.1

аюулгүй байдлын систем

төв удирдлага хяналтын нэгж ба дохиолол илгээх, хаалт, түгжилтийн систем, биет цуглуулга

3.2

конвейр (conveyor)

задгай, бөөн, ширхэгийн ачааг дамжуулан шилжүүлэхэд зориулагдсан, тасралтгүй тээвэрлэх машин

4 Номын сангийн орчны нөхцөл

4.1 Нийтлэг шаардлага

4.1.1 Номын сангийн барилга байгууламжийг барих орчин, газар, номын санг болзошгүй аюулаас сэргийлэх, хамгаалах тоног төхөөрөмж, тэдгээрийг суурилуулах болон галын аюулаас хамгаалахад MNS ISO 11799 стандартыг мөрдөнө.

4.1.2 Үнэт, ховор номын сан хөмрөгийг газар хөдлөлт, гал, усны болон бусад аюулаас хамгаалах тусгай бүтээцийн дагуу барьж байгуулна.

4.1.3 Номын сангийн галын аюулгүй байдлыг хангах үүднээс 50 м² талбай тутам 1 гал унтраагч, өрөө тасалгаа бүрт нэгээс цөөнгүй гал унтраагч байна.

4.1.4 Номын сангийн цахилгааны монтаж, сантехникийн шугам, сүлжээний угсралт нь аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байна.

4.1.5 Номын сан байгалийн гамшиг (газар хөдлөлт, усны үер, салхи шуурга г.м.) бусад болзошгүй аюул (гал, усны аюул, хулгай г.м.)-аас сэргийлэх, даван туулах төлөвлөгөөтэй байна.

4.2 Номын сангийн тэмдэглэгээний системийн байрлал

4.2.1 Номын сангийн гадна талд номын сангийн байрлал болон орчны байдлыг тодорхойлсон таних тэмдэгтэй байна.

4.2.2 Номын сангийн нэр болон бэлгэ тэмдэг (эмблем), ажиллах цагийн хуваарь, тэргэнцрийн зам, машины зогсоол, ном буцаах цэг зэргийг заасан хаяг, дүрс тэмдэглэгээг номын сангийн барилгын харагдахуйц газар байрлуулна.

4.2.3 Номын сан дотор уншигч хэрэглэгчид номын сангийн бүхий л байршилд зүг чигийн баримжааг мэдэх, тухайлбал эргэлт, шат, гадна болон дотоод цахилгаан шат зэрэг байршлыг олоход шаардлагатай тэмдэглэгээ байна.

4.2.4 Гадна талын тэмдэглэгээний гэрэлтүүлгийн хэмжээг орон нутгийн журмаар зохицуулж болно.

4.2.5 Аваарын (ослын) гарцын тэмдэглэгээ нь байрлал, загвар, өнгөний хувьд бусад хаяг тэмдэглээнээс ялгарахуйц байна. Ослын гарц, яаралтай тусламжийн тэмдэглэгээ, багаж хэрэгсэлтэй байна.

4.3 Номын сангийн гадна талбай

4.3.1 Гадна талбайд нэвтрэх зам, машины зогсоол болон үйлчлүүлэгчид зориулсан задгай талбай багтана.

4.3.2 Гадна талбайн дизайныг хүрээлэн буй орчин, газар орны байдал, номын сангийн онцлог, шинж байдалд нийцтэй байдлаар төлөвлөсөн байна.

4.3.3 Яаралтай тусламж (гал түймэр, эмнэлгийн түргэн тусламж) саадгүй нэвтрэхээр байна.

4.3.4 Гадна талбайн төлөвлөлтөд холбогдох мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, санал, дүгнэлтийг авсан байна.

4.3.5 Гадна талбайн 15-25 хувьд нь зам, нэвтрэх хэсэг, хүүхдийн тэрэг, тэргэнцэр, түүнчлэн ачих буулгах талбай болон налуу зам, хогийн сав, дугуйн зогсоол (машины зогсоол орохгүй) байна.

4.3.6 Номын сангийн төв хаалганы өмнөх талбай соёл-олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад хүрэлцэхүйц байна.

4.3.7 Хаалганы өмнө хэсэг (довжоо) шаттай бол хүүхдийн тэрэг болон тэргэнцэртэй үйлчлүүлэгчид зориулсан налуу замтай байна.

4.3.8 Шат нь хоёр талдаа бариултай байх ба шат, талбайн гадаргууг хальтирахгүй материалаар хийнэ.

4.3.9 Зам болон хаалганы орчин гэрэлтүүлэг сайтай, зүг чигийг баримжаалахад хялбар байна. Ном буцаах цэг, автомат төхөөрөмж, шуудангийн хайрцаг зэрэг нь төв /хаалга/ үүдэнд харагдахуйц байх ба эвдрэл, гэмтлээс хамгаалсан байна.

4.3.10 Машины зогсоолын 1 машинд ноогдох талбай (2,5х5,0) м²-аас багагүй, хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид зориулсан машины зогсоол (3,5х5,0) м²-аас багагүй байна.

4.3.11 Номын сангийн гадна болон уншлагын танхимын эргэн тойронд (цэцэрлэг, хашаа) ногоон байгууламжтай байж болно. Ногоон байгууламжийг уулзалт, амралт чөлөөт цагт зориулсан, утасгүй интернет ашиглаж болохоор зохион байгуулна.

Гал унтраах системийн тухай А хавсралтаас үзнэ үү.

4.4 Номын сангийн байрны гэрэлтүүлэг

4.4.1 Ажлын байрны гэрэлтүүлэг 200 люкс (лк) байна.

4.4.2 Уншлагын танхимд байгалийн ба хиймэл гэрэлтүүлэг хосолсон байна.

4.4.3 Сан хөмрөгт байгаа баримтын гадаргууд тусах гэрэлтүүлгийн хэмжээ 50 лк-ээс хэтрэхгүй байна.

4.4.4 Сан хөмрөгт байрлах гэрлийн чийдэн нь номын тавиур, шкаф, баримтын гадаргуунаас 0,5 метрээс багагүй зайд байрласан байна.

4.4.5 Сан хөмрөгт байгалийн ба хиймэл гэрэлтүүлэг хосолсон байхыг зөвшөөрнө. Баримт материалд нарны гэрэл шууд тусахааргүй байвал зохино.

4.4.6 Гэрэлтүүлгийг төлөвлөхдөө баримт материалд сөргөөр үзүүлэх нөлөөг анхаарна.

4.4.7 Сан хөмрөгийг хэсэгчилсэн ба нэгдсэн унтраалгын системтэй, зөвхөн шаардлагатай гэрэл асдаг байхаар тоноглогсон байна.

4.4.8 Шууд бус гэрэлтүүлгийг компьютерийн өрөөнд ашиглана.

4.4.9 Харааны ая тухтай байдлыг бүрдүүлэхийн тулд тодорхой байр талбайн ерөнхий гэрэлтүүлэгт зориулан шууд ба шууд бус гэрэлтүүлгийг хослуулан ашиглана.

Цахилгаан үүсгэвэртэй хиймэл гэрэлтүүлгийн тухай С хавсралтаас үзнэ үү.

4.5 Номын сангийн барилгын дулаан, чийгшил

4.5.1 Сан хөмрөг/хадгаламжийн байрны дулаан ($+18 \pm 2$) °C; агаарын чийгшил (55 ± 5) % байна.

4.5.2 Номын сангийн уншлагын танхим, бусад өрөө тасалгааны дулаан ($+20 \pm 1,5$) °C; харьцангуй чийгшил (45 ± 7) % байна.

4.5.3 Шөнө ба амралтын өдрүүдэд $+17$ °C ÷ $+18$ °C-ээс хэтрэхгүй байна.

4.5.4 Номын сангийн барилга агааржуулалтын системтэй байна.

4.5.5 Номын санд зориулсан агааржуулалтын бичил төхөөрөмж ашиглахыг зөвшөөрнө. Барилгын доторх дулаан, чийгшлийн хэмжээ, агаар солилцоог нэмэгдүүлэх, тоосжилт, бохирдлын түвшинг бууруулах хэвийн нөхцлөөр хангах асуудлыг иж бүрнээр шийдсэн байна.

4.5.6 Номын нөөц хадгалалтын өрөөнд агаарын чийг тохируулагч, дулаан хэмжигч, шавьж устгагч, мөөгжих, тоосжих, чийгшихээс хамгаалах тоног төхөөрөмжтэй байна.

4.5.7 Номын сангийн барилгын агаар солилцооны норм хэмжээг 1 цагт агаар солилцох хэмжээгээр тодорхойлно.

Номын сангийн барилгын агаар солилцох давтамжийн хэмжээг В хавсралтаас үзнэ үү.

4.6 Номын сангийн байрны эрүүл ахуйн нөхцөл

4.6.1 Тоосжилт бохирдлын түвшинг багасгах зориулалттай номын сангийн орчны тоноглолыг зөв шийдэж, борооны усыг түргэн зайлуулагчаар хангасан байна.

4.6.2 Номын санд сар бүрийн төлөвлөгөөт их цэвэрлэгээний өдөртэй байна.

4.6.3 Номын сангийн байран дахь чимээ, шуугианы зөвшөөрөгдөх хэмжээ авианы түвшний “А” шатлалаар 40 дБ байж болно.

4.6.4 Нэмэлт болгож авиа шингээх зориулалтын дотроор хана доторлохыг зөвшөөрнө.

4.6.5 Номын санд дуу авиаг шингээх тавилгыг хэрэглэнэ.

4.6.6 Хүний эрүүл мэндэд хортой, номын өнгө будагт харш нөлөө үзүүлэх материал ашиглахыг хориглоно.

4.6.7 Дуу чимээ ихээр үүсгэдэг агааржуулалт, цахилгаан шат зэрэг нийтлэг үйлчилгээний төхөөрөмж нь нам гүм орчин шаардлагатай өрөө танхимаас тусдаа байна.

4.7 Номын сангийн шаланд тавих шаардлага

4.7.1 Номын сангийн шал нь үйлчлүүлэгч болон ажилтны ая тух, аюулгүй байдлыг хангасан байна.

4.7.2 Шал нь халтирдаггүй, шатамхай бус /галд тэсвэртэй/ байна.

4.7.3 Шат болон налуу зам дээр товгор, хотгор зүйлгүй байна.

4.7.4 Гадна болон дотор шалны зөрүү 2 см-ээс илүүгүй байна.

4.7.5 Номын санд дараах хэлбэрийн шалны хучилтыг ашиглаж болно. Үүнд: хивс, чулуу, хиймэл агрегат, керамик хавтан, хөнгөн шал (хулдаас), мод, наамал болон давхарлагаатай хучилт.

4.7.6 Хэрэв дуу чимээ үүсгэдэг материал ашиглавал хана, таазны бүтцэд дуу шингээгч хавтан ашиглана.

ТАЙЛБАР: Барилгын гаднах орчинд (талбай) байнгын шал буюу зассан талбай байх нь дотор хэсэгт бохирдол үүсэхээс сэргийлнэ.

ТАЙЛБАР: Номын сангийн үүдний орчинд тоос, шавар, ус зэрэг бохирдлоос хамгаалж шалавч ашиглаж болно. Үүнд: төмөр гишгүүр, байгалийн болон синтетик шалавч, гадна зориулсан хивс байж болно. Мөн хаалганы дээд хэсэгт жижиг саравч байвал цэвэр байдлыг хадгалахад тустай.

Дуу чимээний зохистой хэмжээг D хавсралтаас үзнэ үү.

5 Уншигчид үйлчлэх байрны орчин

Номын сангийн уншлага үйлчилгээний орчин дараах шаардлагыг хангасан байна.

5.1 Уншлагын танхим 100 уншигчийн суудлаас илүүгүй байна. Бусад үйл ажиллагаа эрхэлдэг хэлтэс тасгийнхан уншлагын танхимаар дамжин өнгөрөхийг хориглоно.

5.2 Уншлагын танхимын талбайн хэмжээ $(250 \div 300) \text{ м}^2$ -аас ихгүй байна.

5.3 Уншлагын танхимын төлөвлөлтөд чөлөөт сонголтын сан хөмрөг, уншигчид хяналт тавих жижүүрийн номын санчийн ажлын байрыг тусгасан байна.

5.4 Танхимын сул орон зайг тусгаарлан номын сангийн тоног төхөөрөмж байрлуулах, байнгын бус халхлагч гүйлгээ хана, чимэглэлийн торон халхавч

зэргийг байрлуулахыг зөвшөөрнө. Уншлагын танхимд ноогдох талбайг $(100 \div 150)$ м²-аас багагүй байхаар тооцно.

5.5 Номын сангийн үйлчилгээний хүрээнээс хамааран хүүхдэд зориулсан уншлагын танхимгүй байхыг зөвшөөрнө.

5.6 Лавлагаа-мэдээллийн аппаратад зориулсан өрөө, тасалгааг 2-р давхраас дээшгүй, шинэ ном, хэвлэлийн болон сэдэвчилсэн үзэсгэлэн гаргахад тохирсон орчинг бүрдүүлсэн байна.

Уншигчид үйлчлэх байр, уншлагын номын санч ба үйлчлүүлэгчид ноогдох талбайн хэмжээг Е хавсралтаас үзнэ үү.

6 Сан хөмрөг, хадгаламжийн орчин

Номын сангийн сан хөмрөг, хадгаламжийн орчин нь дараах шаардлагыг хангана.

6.1 Үндсэн хадгаламж нь ном олгох ба боловсруулах хэлтэс, тасаг, сэлбэн засах хэсэг, лабораторитай уялдсан байна.

6.2 Солилцооны ба бэлтгэл хөмрөгийг тусдаа байранд байрлуулахыг зөвшөөрнө.

6.3 Гар бичмэл, барын ном, судар болон ганц хувь, ховор ном зохиолыг микрофиш, микрофильм, диск, дижитал хэлбэрт буулган, эхийг тусад нь хадгална.

6.4 Том хэмжээний газрын зураг, зураг, сонин г.м. баримтыг хадгалахад зориулсан байрыг тусад нь эсвэл бие даалган тусдаа байрлуулахыг зөвшөөрнө.

6.5 Томоохон номын сан (200 мянгаас 5 сая хүртэлх нэгжийн хадгаламж) үндсэн хадгаламжаас ашиглалтын дагуу ойрын хөмрөгийг ажиллуулж болно. Ойрын хөмрөг үндсэн хадгаламжийн 20 хувиас хэтрэхгүй байна.

6.6 Сан хөмрөгийн ажилтны ажлын байр нь сан хөмрөг хадгаламжтай цуг байна. Ажилтны ажлын байранд ноогдох талбай 6 м² байна.

6.7 Номын сангийн сан хөмрөг хадгаламжийн байраар бусад үйл ажиллагаа эрхэлдэг хэлтэс тасгийнхан дамжин өнгөрдөггүй байвал зохино.

6.8 Баримт хадгалах байрыг байнгын ба хөдөлгөөнт тавиураар (модон, төмөр) тоноглоно.

6.9 Тавиурыг хананд перпендикуляраар, цонх ба дулааны шугамаас 0,6 метрээс багагүй зайтай байрлуулна.

6.10 Тавиур хооронд нэвтрэх замтай байна:

- тавиур хоорондын зай - 0,75 м;
- сан хөмрөгийн гол хэсэг дэх зай - 1,20 м;
- хана ба тавиур хоорондын зай нь (хананд параллелаар) - 0,75 м;
- хана ба тавиурын эгнээ хоорондын зай - 0,45 м;

- чөлөөт сонголтын тавиур хоорондын зай - $1,0 \text{ м} \div 1,5 \text{ м}$

6.11 Нэг ба хоёр талтай тавиурын өндөр 225 см-ээс ихгүй байна. Тавиурын тавцан хоорондын зай $26 \text{ см} \div 31 \text{ см}$ байна. Шалнаас тавиурын доод тавцан хүртэлх зай 0,15 м, доод давхарт (зоорийн давхар) бол 0,30 м-ээс багагүй байна.

6.12 Сан хөмрөгийн шалны даацын хэмжээ 1 талтай тавиур ашиглахад зориулсан бол 850 кг/м^2 -аас багагүй; 2 талтай тавиур ашиглахад зориулсан бол 1600 кг/м^2 -аас багагүй даацтай байна.

6.13 Хадгаламжийн орчны нөхцөл нь барилгын төлөвлөлт болон хадгалалтын хэд хэдэн хүчин зүйл (температур, харьцангуй чийгшил, гэрэлтүүлэг, цахилгаан соронзон туяа, агаарын бохирдол, чичиргээ)-ээс хамаарна.

6.14 Төрөл бүрийн материал (цаас, пергамент, микрофильм, соронзон тууз, фонограф материал) нь хадгалалтын өөр өөр орчин, нөхцөл шаардана. Урт хугацааны хадгалалт, хамгаалалтад материалыг тус тусад нь төрөлжүүлж хадгална.

6.15 Сан хөмрөгийн орчин дахь тавилга болон бусад тоног төхөөрөмжийг сонгохдоо хадгалалтын аюулгүй байдлыг харгалзан үзнэ.

6.16 Сан хөмрөгийн агааржуулалтын систем агаарын эргэлтийг хангана. Хэрэв байгалийн агааржуулалт хангалтгүй бол нэмэлт агааржуулалтын систем шаардлагатай.

6.17 Өрөөний агаар хий, бохирдол, тоосгүй байна. Гаднаас орох агаар болон барилгын бохирдлыг өрөө хооронд тархаахгүйн тулд шүүлтүүртэй агааржуулалт байна.

Сан хөмрөгийн номын тавиурт ноогдох норм, хэмжээг Е хавсралтаас үзнэ үү.

7 Албан ба туслах байранд тавих шаардлага

7.1 Ном бүрдүүлэх, шинжлэх ухаан- техникийн боловсруулалт, албаны каталог ба бусад каталог зохион байгуулах хэлтэс, тасгийн ажил цогцоор барилгын доод давхарт байрлана.

7.2 Номын сангийн албан өрөө, тасалгааны эзлэх талбайн хэмжээ Олон улсын Номын сангийн холбоо (ОУНСХ)-ны удирдамжийн дагуу уншигчид зориулсан бүсийн талбайн 20 хувиас багагүй байна. Хэрэв тухайн номын сан хэд хэдэн салбартай бол албан тасалгааны талбай 25 хувь хүртэл нэмэгдэж, салбарт 10 хувь хүртэл буурна.

7.3 Номын сангийн ажиллагсдад зориулсан амралтын өрөөтэй байна. Хэрэв том номын сан бол холбогдох хэсэг тус бүрт байна. Амралтад зориулсан 1 суудалд ноогдох талбайн хэмжээ $2,5 \text{ м}^2$, гал тогооны тоног төхөөрөмж байрлуулах талбайн хэмжээ $2,0 \text{ м}^2$ байна. Жишээ нь: 6 - 10 ажилтны өрөө, тасалгааг зохион байгуулахад 12 м^2 талбай хангалттай.

7.3.1 Амралтын өрөөнд амралт, чөлөөт цагт зориулсан тусгай тоног төхөөрөмжөөс гадна эмнэлгийн (эмийн сан, анхны тусламж г.м.) булантай байна.

7.3.2 Амралтын өрөө нь үйлчлүүлэгчид зориулсан анхны тусламжийн хэсэгтэй хамт байна. Тавилга хэрэгсэл, сандал, ширээнээс гадна тусламж шаардлагатай үйлчлүүлэгчийг хэвтүүлэх ор, буйдантай байж болно. Шаардлагатай тохиолдолд тусламж дуудах дохиоллын төхөөрөмжтэй байна.

7.4 Ажлын байрнаас гадна ажиллагсдад шаардлагатай өрөө, тасалгаа (ариун цэврийн өрөө, хувцасны өрөө, цайны өрөө/жижиг гал тогоо, хурлын танхим) байна.

7.5 Үзэсгэлэн болон бусад арга хэмжээ, маркетингийн үйл ажиллагааны бэлтгэлд зориулсан тусгай студитэй байж болно. Өрөө нь их хэмжээний зүйлс хадгалахад хүрэлцээтэй, өөрчлөн зохион байгуулах боломжтой, гэрэлтүүлэг сайтай байна. Будаг, цавуу, уусгагч агуулсан бодис буюу хурц үнэр үүсгэгч бодис ашигладаг бол нэмэлт агааржуулагчтай байна. Студийн өрөөнд $(20 \div 25)$ м² талбай тохиромжтой.

7.5.1 Номын сан уулзалт, хурлын танхимтай байж болно. Хурлын өрөө нь хурлын ширээ, сандал, үзүүлэн таниулгын зай талбайтай байна. Хурлын ширээ нь өрөөний төв хэсэгт байна. Хүн бүр нөүтбүк /зөөврийн компьютер/ бусад зүйлээ тавих зайтай, хурлын ширээний сандал тутам 2,5 м², үзүүлэн таниулгад ойролцоогоор 5 м² талбай ноогдохоор тооцно.

7.5.2 Номын сан бүр ашиглагдаагүй тавилга тоног төхөөрөмжийг хадгалах түр хадгалах буюу агуулахын өрөөтэй байж болно.

7.5.3 Шаардлагатай тохиолдолд ном хэвлэлийн танилцуулга ба бусад арга хэмжээнд зориулсан нөөц тавиур, тоног төхөөрөмж (жишээ нь хөдөлгөөнт тавиур, үзүүлэнгийн тавиур, илтгэгчийн индэр, хөдөлгөөнт хаалт, таславч) байрлуулах орон зай, талбайтай байвал зохино.

7.5.4 Үйлчилгээний ажилтны ажлын байр цэвэрлэгээний багаж хэрэгслээ хадгалахад зориулсан талбайтай, ус авах крант, бохир ус зайлуулах тоног төхөөрөмжтэй байна.

7.5.5 Томоохон номын сан сэлбэн засах өрөөтэй байж болно. Зарим тохиолдолд хавтас, хайрцаг, байгууллагын дотоод хэвлэл, товхимол зэргийг хийнэ. Сэлбэн засах байрыг төлөвлөхдөө мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч, шаланд ирэх ачааллыг тооцсон байна. Сэлбэн засах өрөөний талбай 15 м² ÷ 20 м² байж болно.

7.5.6 Их хэмжээний хуучны ном судар, түүхэн баримт бичиг, материал, тусгай цуглуулга бүхий номын сан сэргээн засах лабораторитой байж болно.

7.5.7 Сэргээн засварлах өрөө нь ховор материалыг хадгалах нөхцлийг хангасан байна. Барилгын төлөвлөлтөд (үнэт, ховор материалын хадгалалт, хамгаалалтын) мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авна.

7.5.8 Үйл ажиллагааны хэлбэрээс хамааран сэргээн засварлах байрын зай талбайг оновчтой хуваарилна. Үүнд:

- Хатаах/цэвэрлэх ажлын;
- Чийглэх ажлын;
- Тоос цэвэрлэгээний ажлын;
- Бохирлогдсон материал цэвэрлэх;
- Сэргээн засварлах ажлын баримт бичгийн зай талбай г.м.

7.5.9 Сэргээн засварлагчийн ажлын ширээний тавцангийн талбай ажилтан бүрт 2 м²-аас багагүй байна. Сэргээн засварлах лабораторид тус тусдаа ажил үүрэг бүхий 4 хүртэл ажилтантай, 200 м² - 250 м² талбайтай байна.

7.5.10 Химийн бодисыг зориулалт бүхий тусгай өрөөнд зохих журмын дагуу хадгална.

7.5.11 Хүйтэн болон халуун усны холболт, түүнчлэн шингэн зүйлээр засах техникийн ажиллагаанд шаардлагатай ус зайлуулах шалны холболтыг хийнэ. Мөн 220 болон 380 вольтын цахилгаанд холбосон байна.

7.5.12 Хүчиллэг цаас хадгалах болон хөгц мөөгөнцөр үүсэхээс хамгаалах нэмэгдэл тоног төхөөрөмжтэй байна.

7.6 Хувилан олшруулах ба тоон хэлбэрт шилжүүлэх хэсэг

7.6.1 Сканнертай ажиллах ажлын байрны талбайн хэмжээ 6 м²-аас багагүй байх ба том хэмжээтэй баримт, материалд зориулсан ширээ, орон зайг тусад нь тооцсон байна.

7.6.2 Том оврын (робот) сканнертай ажиллах ажлын байрны талбай 12 м²-аас (3 х 4) багагүй байх ба сканнерын тал бүрт 1 м талбай чөлөөтэй байхаар тооцно.

7.6.3 Хэрэв номын сан компьютерийн төв/мэдээллийн технологийн өрөөтэй бол мэргэжлийн экспертийн зөвлөмжийн дагуу зохион байгуулна.

7.6.4 Серверийн өрөөтэй бол 2 хаалгатай байна. Тоног төхөөрөмж зөөвөрлөх хаалганы өргөн 182 см, өндөр нь 228 см, ажилтанд зориулсан хаалганы өргөн 1 м, өндөр 2 м байна. Хаалга бүр цоожтой байна.

7.6.5 Серверийн өрөөний талбайн хэмжээ 14 м²-аас багагүй, тусгай материалаар хийсэн зориулалтын шалтай байна.

7.6.6 Серверийн шүүгээний тал бүрт 1 м талбай чөлөөтэй байхаар тооцно.

7.6.7 Өрөөг ус, чийг, тоос шорооноос хамгаалсан байна.

7.6.8 Агааржуулалт болон хөргөлтийн төхөөрөмжтэй байна.

7.6.9 Агаар цэвэршүүлэгч болон гэнэтийн аюулаас хамгаалах систем (утаа мэдрэгч, дулаан мэдрэгч, галын хор г.м)-тэй байна.

7.6.10 Галын аюулаас сэргийлэх технологи, хэрэгслийг ашиглах боломжоор хангасан байна.

ТАЙЛБАР: Номын сангийн ажиллагсдад ноогдох талбай нь гүйцэтгэх ажлын байр, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн хэрэгцээнээс хамаарч харилцан адилгүй байна.

ТАЙЛБАР: Сургалт болон мэдээллийн технологийн хэрэгсэлд нэмэлт зай талбай шаардлагатай.

Албан ба туслах байранд ноогдох норм, хэмжээг Е хавсралтаас үзнэ үү.

8 Номын сангийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд тавих шаардлага

8.1 Номын сангийн тоног төхөөрөмж, тэдгээрийг суурилуулах ба галын дохиоллын системийг ашиглахад MNS ISO 17799 стандартыг мөрдөнө.

8.2 Номын сангийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл нь энэхүү стандартын 4.6.6 ба 4.6.7-д заасан шаардлагад нийцнэ.

8.3 Бүх төрлийн номын сангийн үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт техник технологийг ашиглана. Уншигчид зориулсан интернетийн холболт бүхий хайлтын компьютер, принтер, хувилан олшруулагч, сканнер, дохиолол хамгааллын техник хэрэгсэл (камер, баркод уншигч, соронзон хаалга г.м.), аудио, видео төхөөрөмж, мөн тусгай хэрэгсэл (төрөл бүрийн тавиур, каталогийн шүүгээ, ширээ, сандал, үзэсгэлэнгийн хорго, газрын зургийн зориулалтын өлгүүр, хайрцаг, ном зөөх тэргэнцэр г.м.). Нийтийн номын сан биеийн болон мэдрэхүйн дутагдалтай хүнд зориулсан үйлчилгээний тоног төхөөрөмжөөр хангасан байна.

8.4 Номын сангийн тоног төхөөрөмжийг байнгын найдвартай ажиллуулахын тулд тэднийг сэлбэг хэрэгслээр хангах, хүчин чадлыг сайжруулах, засварлах төлөвлөгөөтэй байна.

8.5 Номын сангийн уншлага үйлчилгээнд зориулсан тавилга, тоног төхөөрөмж хурц ирмэггүй, баримт бичигт шүргэхдээ гэмтэхээргүй байвал зохино.

8.6 Уншигчдын ширээ нь модон тавцантай, сандал нь зөөлөн түшлэгтэй, эрүүл мэндэд харш нөлөөгүй, цэвэр хөвөн даавуун бүрээстэй байна.

8.7 Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн ширээ, сандлын хэмжээг 1-р хүснэгтээс үзнэ үү.

1-р хүснэгт - Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн ширээ, сандлын хэмжээ

Сурагчдын нас	Сандлын өндөр	Ширээний өндөр
6-7	320 мм	550 мм
8-9	360 мм	600 мм
10-13	390 мм	650 мм
13-аас дээш	445 мм	700 мм

8.8 Ном зөөх тэргэнцрийн хэлбэр хэмжээнээс хамааран хадгалах зай талбай харилцан адилгүй байна. Жишээ нь: 2-р хүснэгтийг үзнэ үү.

2-р хүснэгт - Ном зөөх тэргэнцрийн хадгалах зай талбайн хэмжээ

Тэргэнцрийн төрөл	Ном зөөх 10 ш тэргэнцэр хадгалах зай
Албан тасалгаанд ном зөөх тэргэнцэр 40 см – 45 см өргөн, 60 см - 80 см урт	4,5 м ²
Тээврийн ном зөөх тэргэнцэр 40 см – 50 см өргөн, 80 см -100 см урт	6 м ²

Номын сангийн номын тавиурын холбогдох норм хэмжээг энэ стандартын 6.8-6.12 дахь заалт болон номын тавиурт ноогдох норм, хэмжээг Е хавсралтаас үзнэ үү.

8.9 Үйлчилгээний бүх талбай босго болон бусад саадгүй байна. Налуу замын хазайлт 6 хувиас хэтрэхгүй байна.

8.9.1 Олон давхар номын сангийн барилгын зорчигчийн цахилгаан шатны багтаамж багадаа ном ачсан нэг тэргэнцэр болон нэг зорчигч тээвэрлэхэд хангалттай хэмжээтэй байна.

8.9.2 Нийтийн зориулалттай цахилгаан шатны хэмжээ ба хаалганы өргөн дамнуургатай хүнийг чөлөөтэй авч явах боломжтой (хаалгыг хаасан цахилгаан шатны бүхээгний дотор хэмжээ 2 м x 1,5 м; хаалганы өргөн нь 1,2 м; цэвэр өндөр нь 2,15 м-ээс багагүй) байна.

8.9.3 Цахилгаан шатны дотор гадна талын хяналтын самбарыг 85 см өндөрт байрлуулах эсвэл нэмэлт товчлуурын хавтанг төлөвлөсөн байна.

8.9.4 Цахилгаан шат нь хаалгыг онгойлгох, хаах мэдээллийн дуут болон гэрлэн дохио, түгшүүрийн дохиололтой байна.

Номын сангийн зарим тоног төхөөрөмж байрлуулахад ноогдох талбайн хэмжээг Е хавсралтаас үзнэ үү.

9 Хамгаалалт ба аюулгүй байдал

9.1 Компьютерийн системд хадгалсан мэдээллийн аюулгүй байдлыг холбогдох стандартын дагуу хангана.

9.2 Гэнэтийн болзошгүй аюулын үед барилгын нүүлгэн шилжүүлэлтийг төлөвлөлтийн дагуу, эмх журамтай зохион байгуулах дуут дохионы системийг суурилуулна.

9.3 Номын сангийн ажиллагсдыг гэнэтийн болзошгүй аюулын үед ашиглах тавилга хэрэгсэл дэх товчлуур болон дохиоллын даруултай нууцлагдсан системээр хангасан байна.

9.4 Нийтийн болон эрдэм шинжилгээний номын сангийн гэрээр олгох үйлчилгээний хэсэг харуулын байрны ойролцоо байрлах ба оройн цагаар харуулын ажилтан хяналт тавина.

9.5 Ажиллагсдын орох, гарах хаалга болон машин тавих талбай нь хамгаалалтын ажилтан хяналт тавих боломжтой байна.

9.6 Номын сангийн барилгын цонх, хаалга нь гэмт халдлагад өртөх эрсдэлтэй тул сайтар хамгаалсан (дохиолол, шил зүсэгч илрүүлэгч г.м. хамгаалалтын систем) байна.

9.7 Үргэлжилсэн том шилэн хийцтэй барилгын дотор хөдөлгөөн мэдрэгч суулгана.

10 Номын сан-мэдээллийн ажилтанд тавих шаардлага

10.1 Номын сан-мэдээллийн ажилтан нь хэрэглэгч үйлчлүүлэгчид шаардлагатай эх сурвалж мэдээллээ олж авахад идэвхтэй зуучлагч байна.

10.2 Номын сан-мэдээллийн ажилтан нь мэдлэг боловсролоо тасралтгүй дээшлүүлдэг байна.

10.3 Номын сан-мэдээллийн ажилтан нь тухайн нийгмийн нөхцөл байдлыг мэдэрч ажиллах чадвартай, өөрийгөө удирдан зохион байгуулах, хөдөлмөрлөх дадал зүйг эзэмшсэн байна.

10.4 Номын сан-мэдээллийн ажилтан нь хүнтэй соёлч боловсон харилцах, уншигчдын хэрэгцээ шаардлагыг ойлгодог, хамтран ажиллах дадал, соёл боловсролын олон талт байдлыг мэдрэх чадвар эзэмшсэн байна.

10.5 Номын сан-мэдээллийн ажилтан нь тус номын сангийн сан хөмрөгийн талаар мэдлэгтэй, үйлчилгээний зарчмыг ойлгож дэмждэг, үр ашгийг дээшлүүлэхийн тулд бусадтай хамтран ажиллах чадвартай, мэдээлэл харилцааны техник технологийн тодорхой мэдлэгтэй байна.

10.6 Номын сан-мэдээллийн ажилтан нь зохион байгуулах авьяастай, аливаад уян хатан ханддаг, ойрын ирээдүйн чиг хандлагыг мэдэрдэг, шинэ санаа, шинэлэг арга барилыг хүлээн авах чадвартай байна.

Номын санд шаардлагатай орон тооны жишгийг F хавсралтаас үзнэ үү.

Номын сангийн ажлын норм, хэмжээг J хавсралтаас үзнэ үү.

ТӨГСӨВ.

А хавсралт
(мэдээллийн)

Гал унтраах систем

	Систем	Зөвлөнө	Зөвлөхгүй
1.	Шүршигч систем	Нийтэд нээлттэй орон зай	Эмзэг/Мэдрэмтгий материал
2.	Усан манан	Нийтэд нээлттэй орон зай, сан хөмрөг	Ховор материалын цуглуулга (сан хөмрөг)
3.	Хийн зүйлс	Ховор ном материалын сан хөмрөг, мэдээллийн технологийн өрөө	Нийтэд нээлттэй орон зай, уужим, том өрөө тасалгаа
4.	Нүүрстөрөгчийн давхар исэл	Номын санд зөвлөхгүй	Хүн байх орчин

В хавсралт
(мэдээллийн)

Номын сангийн барилгын агаар солилцох давтамжийн хэмжээ

Байр, өрөө, тасалгаа	1 цагт агаар солилцох хэмжээ	
	Оруулах	Татах
Уншлагын танхим	3	2
Каталогийн өрөө	2	1
Вестибюль /үүдний танхим/	-	2
Өлгүүр	-	2
Сан хөмрөг	-	2
Аудио-видео баримтын хадгаламж	-	2
Номын сангийн техник үйл ажиллагааны байр	2	1

С хавсралт
(мэдээллийн)

**Номын санд түгээмэл ашигладаг
